



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/2/

Рашаант сум

**Нэрлэсэн жилийн үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 17.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны "Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Нэрлэсэн жилийн ажлыг аймгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан үр дүнтэй зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Т.Отгонцэцэг, А.Лхагвасүрэн) - т үүрэг болгосугай.

3.Нэрлэсэн жилийн хүрээнд тусгайлсан төлөвлөгөө дотооддоо батлан хэрэгжилтийг ханган, улирал бүр тайлагнаж ажиллахыг сумын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Цэцэрлэг, Сургуулийн захирал, Соёлын төвийн дарга нарт даалгасугай.

4.Нэрлэсэн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг зохих эх үүсвэрээс санхүүжүүлж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д даалгасугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

